МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.02.03 № 08

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар

Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистик мэдээгээр кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг 2012 онд 43, 2013 онд 49, 2014 онд 21, 2015 онд 90, 2016 онд 97, 2017 онд 195, 2018 онд 659, 2019 онд 737, 2020 онд 1795, 2021 онд 4826, 2022 онд 8563 бүртгэгдэж, жил бүр 1-2 дахин өссөн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн зүйл заалтаар нь авч үзвэл, нийт 34 төрлийн гэмт хэрэг кибер орчинд үйлдэгдсэн байх бөгөөд нийт Кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн 7708 буюу 90 хувь нь залилах, 256 буюу 3 хувь нь Кибер орчинд хууль бусаар халдах, 124 буюу 1.4 хувь нь худал мэдээлэл тараах төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Монгол Улсын хэмжээнд бооцоот тоглоомын вэбсайтад хандаж, бооцоо тавьдаг хэрэглэгчдийн тоо нэг зуун мянга давсан бөгөөд үүнээс идэвхтэй хэрэглэгчдийн тоо 15,000-20,000 гэсэн албан бус судалгаа байна. Мөн Монгол Улсын нутаг дэвсгэрт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 20 гаруй агент буюу зуучлагч байгаа бөгөөд эдгээр агентаар дамжин Монгол Улсаас гарч байгаа мөнгө нь нэг сард 10 тэрбум, түүнээс дээш хэмжээнд хүрсэн талаар дурдсан байна.

2024 оны 9-12 сарын хугацаанд “Телеграм” платформ ашиглан үйлдэгдэж буй залилах гэмт хэрэг 619 бүртгэгдсэнээс 10.3 тэрбум төгрөгийн хохирол учирсан байх бөгөөд эдгээр гэмт хэрэг нь арилжааны банкны харилцах дансаар дамжин гүйлгээ хийгдэж, үүнээс нийслэлд 457 хэрэг 6.8 тэрбум, орон нутагт 162 буюу 3.5 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн бүрэн эрхийнхээ хүрээнд цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар дараах асуулгыг Танд тавьж байна. Үүнд:

1. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээ, түүний хэрэгжилт, үр дүн;

2025000013

2. Хууль бус цахим бооцоот тоглоомын хохирлоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалах, хохирлыг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн;
3. Цахим платформ (facebook, telegram, viber, Instagram, whatsapp... гэх мэт) ашиглан үйлдэгдэж буй залилангийн гэмт хэргийн эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, түүний хэрэгжилт, үр дүн;
4. Цахим гэмт хэргийн тоо, хохирлын хэмжээ (гэмт хэргийн төрлөөр, сүүлийн 5 жилийн байдлаар)

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН О.НОМИНЧИМЭГ

2025000013